

  
МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

Хоёр оны 11 сарын 19 өдөр

Дугаар АЧ-5

Мандалговь

Урамшуулал олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. 2020 оны Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу үнэн зөв бүрэн гаргаж зөрчилгүй ажилласан сумдын Төсвийн ерөнхийлөн захирагч, шууд харьцдаг төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч болон санхүүгийн ажилтан албан хаагчдад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг төсөвтөө багтаан хавсралтын дагуу олгосугай.
2. Төсөвт байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу үнэн зөв бүрэн гаргаж зөрчилгүй ажилласан төсвийн шууд захирагч, санхүүгийн ажилтан албан хаагчдад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг төсөвтөө багтаан олгохыг сумдын Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагч наарт зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс ( Г.Энхтайван)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ



431210616